



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠦ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠠᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

᠒᠐᠒᠒ оны ᠐1 сарын 18 өдөр

Дугаар А/19

Алтай хот

**Эрхийн гэрчилгээний хугацаа  
сунгах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.6 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг тус ту сүндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд эзэмшиж байгаа газрын эзэмших хугацааг сунгах хүсэлт ирүүлсэн иргэдийн эзэмших газрын зориулалт, хугацаа, хэмжээг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Эзэмшил газрын хугацаа сунгагдсан иргэдтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээжүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Гаадамба)-т зөвшөөрсүгэй.


3. Газар эзэмшигчид гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2011 оны... дугаар сарын 18-ны өдрийн .../19 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



**ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ  
ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ**

д/д	Аж ахуйн нэгж байгууллагын нэр	Иргэн, аж ауйн нэгж байгууллагын регистрийн дугаар	Газар эзэмших ашиглах эрхийн төрөл	Нэгж талбарын түр дугаар	Газрын хэмжээ (м.кв)	Нэгж талбарын хаяг	Газар эзэмшилтийн зориулалт	Газар эзэмших, ашиглуулах хугацаа
1	З.Бүрэнжаргал	ДЮ666021271	Эзэмших	-	462.0	Оргилбаг	Үйлдвэрлэл үйлчилгээ (2111)	5
2	Г.Ганбат	ДИ62071210	Эзэмших	-	460.0	Оргилбаг	Худалдаа үйлчилгээ (2111)	5
3	Б.Хаш-Эрдэнэ	ДЭ77110913	Эзэмших	-	462.0	Оргилбаг	Үйлдвэрлэл үйлчилгээ (2111)	5